



НИСЛЭГ ТЕХНИКИЙН ОСОЛ, ЗӨРЧЛИЙГ ШИНЖЛЭН ШАЛГАХ АЛБАНЫ 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН

2022.12.24

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зорилго

Нислэг техникийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба /НТӨЗШША/-ны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах асуудлын талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэлээ.

Төлөвлөсөн арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг дүгнэхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2021 оны А/87 дугаар тушаалаар баталсан “Зам, тээврийн хөгжлийн яам болон харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг үндэслэл болгосон.

Хоёр. Танилцуулга

НТӨЗШША-ны 2022 оны үйл ажиллагааг Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт, Сайдын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, Сайдын зөвлөлийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт, Ил тод байдлын үнэлгээ гэсэн 4 үзүүлэлтээр дүгнэсэн бөгөөд нэгдсэн дүнгээр **87.8%**-тай үнэлэгдсэн.

Эдгээрийг тус тусад нь авч үзвэл:

2.1. НТӨЗШША-ны даргын 2022 оны Гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил, үйлчилгээний хэрэгжилтийн байдлыг доорх хүснэгтэд үзүүлэв.

Нийт заалт	Үүнээс						Хугацаа болоогүй	Биелэлтийн хувь
	100%	90%	70%	50%	30%	0%		
19	10	1	8	-	-	-	-	86.8%

НТӨЗШША нь 2022 онд 19 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Нийт 19 арга хэмжээнээс 100%-ийн биелэлттэй 10 арга хэмжээ, 90%-ийн биелэлттэй 1 арга хэмжээ, 70%-ийн биелэлттэй 8 арга хэмжээ, хэрэгжилт дунджаар 86,8%-тай байна.

Хэрэгжилт хангалтгүй арга хэмжээ:

1/ 1.2. Нислэгийн зөрчлийг бүртгэх мэдээлэх, цахим хуудасны үйл ажиллагааг шинэчлэн сайжруулна. /Жилийн эцсийн байдлаар: Мэдээллийг цахимжуулах цахим хуудасны үйл ажиллагааг сайжруулж шинэчилсэн байна/

Биелэлт: Цахим хуудсыг дотоод нөөц бололцоог ашиглан шинээр хийлгэх ажиллагаа явагдаж байна. Цахим хуудсанд орох мэдээлэл, ашиглах зарчим, шаардлагатай үзүүлэлт зэргийг бэлтгэн өгч байна.